

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн сургалтын өнөө ба ирээдүй

The Present and Future of Accountancy Education

Л. Наранчимэг¹

Хураангуй

МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн сургалтын үйл ажиллагааны товч танилцуулга, бакалаврын болон магистрын хөтөлбөрийн боловсролын зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLO) сургалтын төлөвлөгөөний шинэчлэлтийн гол онцлогууд, орчин үед төгсөгчдөд тавигдаж буй ур чадварууд болон даяарчлагдсан, автоматчилагдсан өнөө үед нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн агуулгыг хянан сайжруулах шаардлага байгаа талаар тусгасан болно.

Түлхүүр үгс: сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүнгүүд, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэнд тавигдах ур чадварууд

Abstract

This document provides a brief introduction of the educational activity of the Accounting Department of the National University of Mongolia and information on program goals for the bachelor and master, the learning outcomes of the program (PLO), the main features of the curriculum, and modern skills for graduates. It also highlights the need to train accounting professionals and revise the curriculum content.

Keywords: curriculum, educational goals of the program, learning outcomes, skills for accounting professionals

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим, Доктор (Ph.D)
E-mail: naranchimeg_l@num.edu.mn

Улс орны хөгжлийн өнөөгийн түвшин, бэлтгэж буй мэргэжлийн онцлог байдал, дээд боловсролын шаталсан тогтолцооны нийтлэг жишиг, Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн боловсролын шинэчлэлтийн дэлхий нийтийн чиг хандлагын дагуу сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг улам бүр хөгжүүлэх, сургалтын орчин нөхцлийг сайжруулах замаар олон улсын

жишигт нийцэхүйц, хөрвөх чадвартай мэргэжилтнийг бэлтгэх ээлжит зорилтыг дэвшүүлсэн дунд хугацааны (2016-2024 оны) стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бид нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн хөгжлийн чиг хандлага, ажил олгогчдын эрэлт, хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн хөтөлбөрийн зорилго,

Хүснэгт 1. НББ-ийн тэнхимийн болон хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүнгүүд

Тэнхимийн зорилго	
Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн судлаачдыг бэлтгэдэг Монгол Улсын шинжлэх ухаан, дээд боловсролын тогтолцоонд тэргүүлэх үүрэгтэй эрдэм оюуны төв болох юм	
Бакалаврын хөтөлбөрийн боловсролын зорилго	
Магистрын хөтөлбөрийн боловсролын зорилго	
Шинжлэх ухаанд суурилсан бүтээлч сэтгэлгээ, логик хандлагыг хэрэглэдэг, мэргэжлийн ёс зүйг дээдэлдэг, нягтлан бодох бүртгэлийн онолын болон практик мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшсэн мэргэжлийн нягтлан бодогчийг бэлтгэх явдал юм.	
Мэргэжлийн онол, арга зүйг хөгжүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, судалж буй асуудлын хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийн хувилбар боловсруулж шийдвэр гаргалтанд ашиглах, оновчтой сонголт хийхэд шаардагдах ур чадвар, ёс суртахууныг төлөвшүүлэхэд оршино.	
Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOs)	
PLO1	Нягтлан бодох бүртгэлийн шинжлэх ухаан болон бизнесийн бусад судлах зүйлийн хамт мэргэжлийн нягтлан бодогчдын эзэмшвэл зохих мэдлэг
PLO2	Техникийн болон мэргэжлийн ур чадвар (зохион байгуулах ба бизнесийн удирдлагын ур чадвар, хувийн ур чадвар, мэргэжлийн шийдэл гаргах ур чадвар, мэргэжлийн болон шаардлагатай программ хангамжуудыг ашиглах чадвар)
PLO3	Харилцагчдын хүрээнд үр дүнтэй харилцах
PLO4	Тодорхой зорилгод хүрэхийн тулд багаар үр бүтээлтэй ажиллах
PLO5	Мэргэжлийн үнэ цэнэ, ёс зүй, хандлага (хараат бус байдал, найдвартай байдал, шударга ёс, хянамгай байдал, цаг хугацаандаа байх, зөв бодолтой хүндэтгэлтэй байх, хариуцлагатай байх, найдвартай байдал, хууль дүрэм ба зохицуулалтууд, нийгмийн хариуцлагад мэдрэмжтэй хандах)
PLO6	Насан туршийн боловсролын хэрэгцээг ойлгох, суралцахыг эрмэлзэх
PLO7	
PLO8	

суралцахуйн үр дүнг дараах байдлаар тодорхойлж улмаар хөтөлбөрийн үнэлгээг хийж ажиллаж байна.

Мэргэжлийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн бэлтгэн гаргаж буй мэргэжилтнүүдийн чанарт түлхүү анхаарч тэнхимийнхээ стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Одоо манай тэнхим 21 багштай. Үүнээс зөвлөх профессор 1, профессор 2, дэд профессор 7, ахлах багш 4, багш 7 гэсэн бүрэлдэхүүнтэй сургалт, эрдэм шинжилгээний ажлаа явуулж байна. Бизнесийн удирдлагын бакалаврын чиглэлээр бүгд 625 оюутан, үүнээс идэвхтэй суралцаж буй 481 оюутан, магистрын түвшинд 196 (мэргэжлийн 135, судалгааны 61) оюутан, бизнесийн удирдлагын докторантурт 183 оюутан суралцаж байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 80 гаруй хувьтай байна.

Бакалаврын түвшний оюутнууд нь өөрсдийн хүсэлтээр нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэл - хяналт шалгалт, татварын нягтлан бодох бүртгэл, нягтлан бодох бүртгэл - мэдээлэл зүй

гэсэн гүнзгийрүүлсэн чиглэлээр суралцаж байна.

Тус тэнхим Бүртгэл-санхүүгийн тэнхим нэрээр 1958 онд байгуулагдсанаас хойш 63 удаагийн төгсөлт хийж 7,371 дээд боловсролтой мэргэжилтэн (бакалаврын зэрэглэл), Бизнесийн удирдлагын 809 магистр, бүгд 8,180 мэргэжилтэн бэлтгэжээ (Хүснэгт 2, НББ-ийн тэнхим, 2018).

Манай улс зах зээлийн харилцаанд шилжиж, тэнхимийн хариуцан заадаг хичээлүүдийн агуулга өөрчлөгдөж, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг дагаж мөрдөх болсноор багш нараа давтан сургаж мэргэжлийг нь дээшлүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн хуучин тогтолцоог өөрчлөн шинэчилж дэлхийн улс орнуудын жишигт нийцүүлэх шаардлага 1990-ээд оноос тавигдсан юм. Энэ шаардлагын дагуу тус тэнхимийн багш нар Азийн Хөгжлийн Банкнаас зохион байгуулж санхүүжүүлсэн “Монгол Улсын бүртгэл, аудитын чадавхийг хөгжүүлэх” хоёр шатны төсөлд хамрагдан мэргэжлийн цуврал семинарууд болон бусад сургалтад хамрагдан мэргэжлээ дээшлүүлсний дээр сургалтын агуулга, хөтөлбөрийг дэлхийн

Хүснэгт 2. Тэнхимийн 60 жилд бэлтгэсэн мэргэжилтэн

№	Арван жилээр	Төгсөгчдийн тоо						Магистр (орой)
		өдөр		Орой	Эчнээ	Бүгд	х/жин	
		4 жил	3 жил					
1	1958-1967	107				107	1.4	
2	1968-1977	342		200	49	591	8.0	
3	1978-1987	758	306	485	260	1,809	24.5	
4	1988-1997	464	192	30	187	873	12.0	30
5	1998-2007	481		283	409	1,173	16.0	222
6	2008-2017	1,092	53	825	299	2,269	30.7	428
7	2017-2018	163		9	12	184	2.5	45
8	2018-2019	137		11	16	164	2.2	44
9	2019-2020	157		8	12	177	2.4	26
10	2020-2021*	24				24	0.3	14
	Дүн	3,725	551	1,851	1,244	7,371	100	809
	Хувийн жин	50.5	7.5	25.1	16.9	100	х	

* 2020-2021 оны хичээлийн жилийн өвлийн төгсөлтийн оюутны тоо

улс орнуудын нийтлэг жишигт ойртуулан ээлж дараагаар шинэчлэн, мэргэжлийн шаталсан (бакалавр, магистр, докторын) сургалтын нийтлэг жишиг, олон улсын стандартын дагуу сургалтыг явуулах орчин, нөхцлийг бүрдүүлэх алхамууд амжилттай хэрэгжиж ирсэн бөгөөд одоо ч энэ шинэчлэлт үргэлжилж, тасралтгүй хөгжин өөрчлөгдөж байна.

Сургалтын агуулга, орчны шинэчлэлтийг хэрэгжүүлсний үр дүнд нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн өөрийн үнэлгээг 2001 онд хийж, 2006 онд “Нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн бизнесийн удирдлага” мэргэжлээр бакалаврын зэрэг олгох өдрийн сургалтын хөтөлбөрийг МУИС-ийн хэмжээнд анх удаа магадлан итгэмжлэл хийлгэн Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн гэрчилгээ авсан нь мэргэжлийн сургалтын агуулгын өөрчлөлтийн нэгэн томоохон үнэлгээ болсон гэж дүгнэж болно.

Бакалаврын хөтөлбөрийн ахиц дэвшлийн (хоёрдахь шатны) тайлангаа 2012 онд бэлтгэж, магадлан итгэмжлэлийн гэрчилгээгээ сунгуулсан бөгөөд бүртгэл тайлагналын систем улам бүр даяаршиж, бэлтгэж буй мэргэжилтний суурь болон мэргэжлийн бэлтгэл, практик үр чадварыг олон улсын жишигт хүргэж, хүлээн зөвшөөрөгдөх боломжийг хангахын тулд мэргэжлийн хөтөлбөрөө Бизнесийн сургуулийн хөтөлбөрүүдийн хамт олон улсын байгууллага (ACBSP)-аар 2013 онд, магистрын хөтөлбөрөө 2019 онд тус тус магадлан итгэмжлүүлсэн зэрэг нь мэргэжлийн сургалтын агуулга, бүтцийн шинэчлэлт, сургалтын орчин нөхцөл, удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, өөрийн үнэлгээг хөгжүүлэхэд томоохон ахиц дэвшлүүд болсон юм.

МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн төрөлжүүлэлт, бүтцийн өөрчлөлтийн дагуу Эдийн Засгийн Сургууль (ЭЗС)-ийг 2014 онд өөрчлөн байгуулж, эдийн засгийн мэргэжлийн анги тэнхимүүд нь Шинжлэх Ухааны Сургуулийн Нийгмийн ухааны салбарт шилжин, зөвхөн Бизнесийн чиглэлийн хөтөлбөр, тэнхимүүдээс бүрдсэн Бизнесийн Сургууль (БС)-ийг бие даалган байгуулж ажиллуулах болсноор сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн шинэчлэлт одоо ч үргэлжилсээр байна.

2008 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн Бизнесийн удирдлагын бакалавр бэлтгэх стандарт амьдралд хэрхэн биеллээ олж хэрэгжиж байгааг ЭЗС-ийн нэрээр 2012 онд батлагдсан болон БС-ийн нэрээр 2015 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний зэрэгцүүлэлтээр харууллаа.

Бүхэлд нь аваад үзвэл судлах хичээл тус бүрийн агуулгын хэмжээ ойролцоогоор 3 багц болон жигдэрч, хичээлийн тоо 40 болж өмнөх үеийнхээс ялимгүй нэмэгдсэн, тэр дундаа мэргэшүүлэх хичээлийн тоо 2-3 дахин нэмэгдэж, суралцагчдыг мэргэшүүлэхэд илүүтэй анхаарах болсон онцлогууд харагдаж байна (Хүснэгт 3).

ЭЗС-ийн 2012 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөгөөр ерөнхий суурь хичээлийн хувийн жинг стандартаас 10 хувиар багасгаж, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийг нэмэгдүүлсэн, мэргэжлийн суурь хичээлийн сонгох боломж дөнгөж 5.6 хувь болон эрс багассан зэрэг өөрчлөлтүүд орсон бол 2015 онд батлагдсан БС-ийн (одоо мөрдөж байгаа) төлөвлөгөөгөөр мэргэшүүлэх хичээлийн хувь оролцоо 50 хувь болж стандартаас 20 хувиар

Хүснэгт 3. Бизнесийн удирдлагын "Нягтлан бодох бүртгэл" мэргэжлийн сургалтын төлөвлөгөө (хөтөлбөр)-ний шинэчлэлт

№	Судлах хичээлийн төрөл	Нийт багц цаг		Үүнээс: Заавал судлах		Судлах хичээлийн тоо
		Дүн	х/жин	Багц цаг	х/жин	
1	2008 онд батлагдсан стандартаар					
	1.1 Ерөнхий суурь хичээл	36	30.0	24	66.7	12
	1.2 Мэргэжлийн суурь хичээл	48	40.0	32	66.7	16
	1.3 Мэргэшүүлэх хичээл	36	30.0	30	83.3	12
	Дүн	120	100.0	86	71.7	40
2	2012 онд батлагдсан ЭЗС-ийн төлөвлөгөөгөөр					
	2.1 Ерөнхий суурь хичээл	24	20.0	15	62.5	8
	2.2 Мэргэжлийн суурь хичээл	54	45.0	51	94.4	18
	2.3 Мэргэшүүлэх хичээл	42	35.0	30	71.4	14
	Дүн	120	100.0	96	80.0	40
3	2015 онд батлагдсан БС-ийн төлөвлөгөөгөөр					
	3.1 Ерөнхий суурь хичээл	33	27.5	30	90.9	11
	3.2 Мэргэжлийн суурь хичээл	27	22.5	15	55.5	9
	3.3 Мэргэшүүлэх хичээл	60	50.0	42	70.0	20
	Дүн	120	100.0	87	72.5	40

нэмэгдсэн, тэр хэмжээгээр ерөнхий болон мэргэжлийн суурь хичээлийн хувийн жин буурсан, тэгэхдээ мэргэжлийн суурь хичээлийн сонгох боломж нэмэгдсэн зэрэг өөрчлөлтүүд оржээ.

Сүүлийн жилүүдэд заавал судлах хичээлийн хувийг багасгаснаар сургалтын чөлөөт байдал, оюутан бүр өөрийн сонирхсон чиглэлээр багц бүрдүүлж суралцах, хос мэргэжил эзэмших боломж нэмэгдсэн нь сайшаалтай хэдий ч ерөнхийдөө эдийн засаг, нийгэм улс төрийн болон математик, гадаад хэл зэрэг суурь боловсролын хичээлийн сонголт багасаж, бизнесийн ухааны хичээлүүд эрс нэмэгдэж, мэргэжлийн сургалтанд ангийн ажил бичүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын хугацаа багассан зэрэг хандлагууд байна. Ангийн ажлын оронд хичээл тус бүрээр оюутанд бие даалтын даалгавар өгч дүгнэх, илтгэл эссэ бичүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын тухайд байгууллагын бизнесийн болоод программ хангамж, тоо мэдээллийн нууцлал, дадлагын удирдагчдын чадвар,

оюутанд туслах сэтгэлийн дутмагаас болж дадлагын чанар болон бүтээлч байдал буурч ирснийг нөхөх зорилгоор танхимын дадлага хийлгэх, оюутан төгсөгчдийн үнэлгээг зөвхөн эзэмшсэн мэдлэгээр нь төдийгүй, цаашдаа бие даан ажиллах дадлага чадвар, нийгмийн төлөвшлөөр нь үнэлж дүгнэхэд илүүтэй анхаарах боллоо. Төгсөлтийн дараах буюу магистр, докторантурын сургалт 1990-ээд оны дунд үеэс жигдэрч, 34 удаагийн төгсөлтөөр Нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн Бизнесийн удирдлагын 809 магистр бэлтгэж, сүүлийн жилүүдэд судалгааны магистрын тоо буурч байна. Тус тэнхим нь 2015 оноос үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний магистрын ангийг шинээр нээж өнгөрсөн хугацаанд 16 оюутан уг хөтөлбөрөөр төгссөн байна.

Төгсөлтийн дараах сургалтын хувийн жин нэмэгдэж, сургалтын агуулга, бүтэц сайжран, хөтөлбөр нь шинэчлэгдэж, суралцагчдын эрэлт нэмэгдэж байгаа нь онолын болон суурь судалгааг хөгжүүлэн,

сургалт, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэхэд нэн ач холбогдолтой, их сургуулийн үндсэн хэв шинжийн нэгэн чухал шалгуур үзүүлэлт юм.

МУИС-ийн магистрийн хөтөлбөрийн агуулгын хэмжээ нь бакалаврын үндсэн боловсрол (120 багц цаг) дээрээ 1.5-2.0 жилийн хугацаанд 30-32 багц цаг нэмж цуглуулах бөгөөд нийт судлах хичээлийн 30-40 хувийг мэргэжлийн суурь, 50-55 хувийг мэргэшүүлэх хичээлүүд эзэлж, ерөнхийдөө бакалаврын сургалтаар эзэмшсэн чиглэлээр нь улам бүр мэргэшүүлэх бодлогыг баримталж ирлээ.

Бизнесийн удирдлагын мэргэжлийн онцлогоос хамааран мэргэжил тус бүрээр судлах мэргэшүүлэх хичээлийн тоо хэмжээ, нэр төрөл нь ялгаатай төдийгүй, Нягтлан бодох бүртгэлийн магиструудад голчлон судалгааны болон бизнесийн оновчтой шийдвэр гаргалтын арга зүйн ахисан түвшний 10-12 нэрийн хичээлийг санал болгож, суралцагчдын сонгосон хэмжээгээр нь 5-6 хичээлийг зааж байна.

Сүүлийн жилүүдэд БС-ийн магистрантурд элсэгчдийг зөвхөн эдийн засаг, бизнесийн удирдлагын мэргэжлээр бакалаврын боловсрол эзэмшсэн байх гэсэн хязгаарлалтгүйгээр сонирхсон хүмүүсийг элсүүлэн бэлтгэл ангиар дамжуулан суралцуулдаг болсон, бас суралцагчдын боломж, цаашид үргэлжлүүлэн суралцах сонирхлыг нь харгалзан мэргэжлийн (буюу сургалтын) болон судалгааны хэлбэрээр төгсөлтийг хийлгэдэг уян хатан хэлбэрүүдийг туршин мөрдөх боллоо.

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд автоматчилагдсан ухаалаг системүүд нэвтэрч, эдийн засгийн тодорхойгүй, тогтворгүй байдал нэмэгдэж компьютерийн программ хангамж сайжрахын хэрээр НББ-ийн мэргэжлийн

даяарчлал, стандарчилал, бизнес дэх үүлэн тооцоолол, мэргэжлийн шинэ үеийнхний ялгаатай хүсэл эрмэлзлэл болон шинэ хүлээлтүүд бий болсоор байна.

АССА-ийн гүйцэтгэх захирал Хэлэн Бренд “Хурдацтай өөрчлөгдөж буй дижитал цаг үед амжилттай байхын тулд нягтлан бодогч нь мэргэжлийн мэдлэг, ур чадвараас гадна бусад ур чадваруудыг эзэмсэн байх хэрэгтэй” (Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалт, 2018).

Ирэх жилүүдэд бидний, та бүхний өмнө тулгарах оюун санааны 3 үндсэн сорилт байна. Нэгдүгээрт: big data, machine learning, 5G, аж үйлдвэрийн IV хувьсгалын хэрэглээ улам бүр тэлэх нь тодорхой болоод байна. Дараагийн нэг том сорилт бол дэлхийн улс орнууд, тивүүдийн хоорондын баялгийн тэгш бус хуваарилалтын асуудал юм. Гуравдугаарт: байгаль орчны эрс өөрчлөлт нь маш том асуудал болохоор байна. НББ-ийн ажил мэргэжил нь зөвхөн тоо, статистиктай ажилладаг бус нэн чухал олон чадварыг нэгтгэн өөртөө төлөвшүүлсэн байхыг шаарддаг болсон. Үүнийг “ёс зүй” гэж нэг үгээр дүгнээд хэлбэл оновчтой болов уу. Чухам энэ л НББ-ийн мэргэжлийн гол цөм юм (Ali, 2020).

Стратеги төлөвлөгөөнд зааснаар мэргэжлийн боловсролын сургалтандаа дараах чиглэлүүдийн өөрчлөлтийг хийхээр ажиллаж байна.

1. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан оюутнууддаа насан туршдаа суралцахуйг дэмжих,
2. МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмын дагуу хөтөлбөрийн сайжруулалтыг тогтмол хийж байгаа ч цаашид хөтөлбөрийн үнэлгээг богино хугацааны

үечлэлээр хийж, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөтөлбөрийг сайжруулах. (ERP систем нэвтрүүлэлт, хиймэл оюун ухааны хэрэглээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл технологийг ашиглах чадвар, сэтгэл судлал, карьер өсөлт, байгууллага дахь бүтээлч сэтгэлгээ ба инноваци зэрэг хичээлүүдийн агуулгыг сургалтын төлөвлөгөөнд оруулах),

3. Академик болон мэргэжлийн мэргэшлийн зэргийг дүйцүүлэх зэрэг цол олгох (хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх),
4. Мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх.

Алгоритм, хиймэл оюун ухаанд суурилж олон чухал шийдвэрийг гаргах болсон өнөө цагт хүний хүчин зүйл ч чухал хэвээр байгааг манай салбараас харж болно. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар хомсдолтой ажил мэргэжилд нягтлан бодогчийн мэргэжил багтсаар байна (ХНХЯ, 2019).

Олоннийтийн сайн сайхны төлөө, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, байгаль орчноо хамгаалах үндсэн чиглэлийг барьж аливаа шийдвэрийг гаргадаг болсон цагт аливаа бизнес тогтвортой урт хугацаанд амжилттай явах боломж бүрдэнэ. Дижитал технологийн хөгжил, дата аналитикс, автоматжуулалтын үсрэнгүй хөгжлийн үр дүнд нягтлан бодогчид байнга хийдэг зарим ажлыг гараар хийх шаардлагагүй болсон бөгөөд нягтлан бодогчдын ажил илүү үнэ цэнэтэй болж мэдээллийг нэгтгэхээс илүү нэгтгэн дүгнэх рүү шилжиж байна.

Дүгнэлт

Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулалт, тооцооллын ажиллагаа нь улам бүр компьютержиж, мэргэжилтний оролцоо багасах хандлага байгаа ч Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар дээд боловсрол шаардах эрэлттэй мэргэжлийн жагсаалтад нягтлан бодогчийн мэргэжил орсоор байна.

МУИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхим нь 1958 онд анх байгуулагдсанаас хойш 63 удаагийн төгсөлт хийж 7,371 дээд боловсролтой мэргэжилтэн (бакалаврын зэрэглэл), бизнесийн удирдлагын 809 магистр, бүгд 8,180 мэргэжилтэн бэлтгэжээ. Төгсөгчид нь улс орны бүхий л салбарт амжилттай ажиллаж байна. Даяарчлагдсан, автоматчилагдсан өнөө үед нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн агуулгыг хянан сайжруулж, тэдэнд чухам ямар мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх вэ (НББОУСЗ, 2017) гэдгийг эргэн харж шүүн хэлэлцэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэргэжлийн нягтлан бодогчийн чадамжийн хүрээг боловсруулах шаардлага тавигдаж байна.

Мэргэжлийнхээ ур чадвараа хөгжүүлэхэд тасралтгүй анхаарч, бизнесийн зөвлөх үйлчилгээнд суралцаж, мэргэжлийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамтарч ажиллах, харилцан суралцах, ёс зүйтэй байх эрхэм чанарт илүү суралцах нь бидний амжилтын хөдөлгүүр болох төдийгүй дэлхийн хөгжлийн чиг хандлагад бэлэн байх боломжийг олгоно.

Ажлын байраа дэлхийн хэмжээнд сэтгэж, дижитал технологийг ашиглах нь мэргэжилд улам их давуу талыг бий болгоно.

Ашигласан материал

Ali, R. (2020). *ACCA - Panel Discussion: Future of Education*.

Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтын илтгэлүүд (2018).

НББ-ийн тэнхим (2018). *НББ-ийн тэнхим 60 жилийн түүхэн замнал*.

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл - НББОУСЗ (2017). *Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандарт*.

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам - ХНХЯ (2019). *Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн Барометрийн судалгаа*.